

МОУИТБС-ын 2015 оны нэгтгэл Эхлэлийн семинарын хурлын тэмдэглэл

Он сар өдөр	2016 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 10.00-13:00 цагт
Байршил	Пума Империа зочид буудал
Зохион байгуулагч	МОУИТБС-ын Ажлын алба, Харт Нойрс Лтд болон Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн консерциум

МОУИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нээлтийн үг хэллээ.

Өнөөдөр МОУИТБС 2015 оны нэгтгэл тайлан хийх ажлын эхлэлийг тавьж байгаа. Энэ ажилд “Улаанбаатар аудит корпораци” ХХК шалгарсан.

Тендерийн шалгаруулалт нэлээд хүндрэлтэй явсан. Уг нь 2-р сард аудитор нь томилогдоод, 3 сард энэ семинарыг зохион байгуулах төлөвлөгөөтэй байсан боловч тендерийн үйл явцын улмаас нэлээд хоцорч байна.

Өнөөдөр ажил төрлөө зохицуулаад, цаг гарган ирсэн та бүхэнд баярлалаа.

Хөтөлбөр ёсоор багийн ахлагч Н.Эрдэнэцогийг семинар эхлүүлнэ үү гэж урья.

Н.Эрдэнэцог: Ажлын хэсгийн гишүүдэд тарааж өгсөн материалын дагуу танилцуулга эхлүүлэв.

ОТАХ-ээс 2015 оны нэгтгэлийн тайланд аль стандартыг баримтлахыг тодруулав.

Ш..Цолмон: Лимад шинэ стандарт батлагдсан. 2016 оны стандартаар томоохон өөрчлөлт гараагүй. Тийм учраас 2016 оны стандартаа дагаж мөрдөөд явах саналтай байгаа.

Ажлын хэсгийн бусад гишүүдээс санал гаргаагүй.

Н.Эрдэнэцог: Бид нарт шинэ стандартаа дагаж, мөрдөөд явахад ямар нэгэн хүндрэл байхгүй.

Н.Эрдэнэцог: Ажлын албаны зүгээс 2014 оны тайлангийн зөвлөмжийн хэрэгжилтийг Эхлэлийн семинарийн үед ОТАХ-ийн гишүүдийн хүрээнд ярилцах хүсэлт тавьсны дагуу хэлэлцүүлэгт оруулж, ОТАХ-ийн дүгнэлтийг сонсох нь зүйтэй гэж үзсэн.

Г.Ганбат: Би эхний 2 зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой тайлбар хэлчих үү.

Эхний зөвлөмж нь Мэдээллийн технологийн хяналттай холбоотой асуудал байсан. Энэ зөвлөмжийн гол асуудал нь мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдалд эрсдэл учруулж болзошгүй, сул орчин байж болзошгүй, тийм учраас хяналт тавих ёстой гэсэн зөвлөмж байсан. Энийг энэ жилийн ажлын даалгавраар Улаанбаатар аудит

компанид өөрт нь даалгасан байгаа. Эрх авсан хэрэглэгчийн үүрэг, нууц үг өөрчлөх боломжгүй байдал зэрэг дутагдлуудыг зассан байгаа.

Төлбөрийн мэдээллээс гадна Нэмэлт мэдээллийг цахим тайлангийн системээр цуглуулах боломжийг судлах гэсэн зөвлөмж хэрэгжсэн. Энэ жилийн нэгтгэл тайлангийн нэмэлт мэдээллийг цахимаар авах болно. 2-р зөвлөмж ерөнхийдөө хэрэгжсэн гэж үзэж болно.

Ш.Цолмон: Зөвлөмжүүдийг явцын дунд яриад явъя.

Б.Батболд: Хэрэгжилтийг энэ тараах материалд гаргаагүй юм байна. 2 дугаарт зөвхөн өмнөх тайлангаас гаргасан 12 зөвлөмж биш, манай Иргэний нийгмийн санаачилгаар урьд өмнө, өмнөх жилүүдэд гаргасан бүх зөвлөмжүүд дээр үнэлгээ хийсэн байгаа. Энэ үнэлгээг үндэслээд гарсан тэр асуудлууд дээр анхаарлаа хандуулна уу гэж хүсмээр байна. Өмнөх жилүүдийн зөвлөмжүүдийг нэгтгээд, одоо цаашид ийм асуудлууд дээр анхаарах ёстой гээд дүгнэлт гаргасан байгаа. Тэгэхээр тэр дүгнэлтүүд дээр гол анхаарлаа хандуулбал зүйтэй. Тэрнээс биш ганцхан өмнөх тайлангийн 12 зөвлөмж дээр анхаарлаа хандуулаад байвал энэ чинь явцын дунд стандартууд өөрчлөгдөөд явж байсан, тэрэнтэй холбогдолтой зөвлөмжүүд байгаа ш дээ. Яахав нийт багцаар нь харвал жил болгон 1 зөвлөмж гардаг, тэрний үр дүн юу юм гэдэг дээр гол анхаарлаа хандуулж, дараагийн тайландаа асуудлуудыг оруулж ирвэл зүгээр юм болов уу гэж шууд хэлэх гээд байна. Тэрийг ер нь та нар үзсэн үү?

Н.Эрдэнэцог: Үзсэн. 2013 оны нэгтгэл хийгдэх явцад энэ асуудал яригдаж байсан. ТББ-аас бүх өмнөх жилүүдийн зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгээд хэрэгжих боломжтой нь ямар, боломжгүй нь, хэрэгжих явцдаа байгаа нь ямар байна гэснийг дүгнэснийг мэдэж байгаа. Тэхдээ яахав ажлын даалгаварт зааснаар өнгөрсөн жилийн зөвлөмжийн хэрэгжилтийг ажлын хэсгээс тодруулж, тайланд оруулах ёстой гэсэн асуудал байгаа. Тэгэхээр бид нар таны саналыг хүлээн авч болж байна. Тэр зөвлөмжийг тайланг аваад, ер нь өнөөдрийн түвшинд ямар байгаа, энэ өнгөрсөн жилийнхтэйгээ нийлүүлээд, он оноор нь гаргаж, нийлүүлээд гаргаж болно.

Ш.Ш.Цолмон: За уучлаарай. Б.Нямаа зөвлөх ирсэн байна. МООИТБС-ын Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын хэсгийн ахлагч, МУ-ын Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Нямаа удирдлага шинээр томилогдсон байгаа. Ажлын хэсгийн гишүүд болон бусад хуралд оролцогсод өөрсдийгөө танилцуулаад явчих уу?

1. МУ-ын Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Нямаа
2. МООИТБС-ын Ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон
3. Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Н.Оюунцэцэг
4. Гаалийн ерөнхий газрын статистикийн газар Ж.Батцэнгэл
5. МБОИЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд
6. Нээлттэй нийгэм форумын менежер Д.Д.Эрдэнэчимэг
7. Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан
8. МООИТБС-ын ажлын албаны ахлах ажилтан Г.Ганбат
9. МООИТБС-ын санхүүгийн мэргэжилтэн А.Отгонтунгалаг
10. АТГ-ын төлөөлөл, н.Дуламсүрэн
11. Оюу толгой ХХК-ийн төлөөлөл Ренчинпагма
12. Ил тод сан ТББ-ын Гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав
13. Эрдэнэс таван толгой ХХК-ийн төлөөлөл н.Гэрэлмаа
14. Монголын байгаль эхийн аврал сан ТББ-ын тэргүүн Н.Наранцэцэг

15. Транспарэнси интернэйшнл-Монгол байгууллагын Ерөнхийлөгч Л.Төр-Од
16. МБОИЗ-ын төлөөлөл Алтанцацрал
17. Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн Аудитын менежер Н.Эрдэнэцог
18. Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн Ахлах аудитор Б.Дэлгэрмаа

Ажлын хэсгийн ахлагч Б.Нямаа: Үг хэлэв.

Н.Эрдэнэцог танилцуулгаа үргэлжлүүлэв. Материаллаг байдал ба цар хүрээг тодорхойлох асуудлыг танилцуулав.

Ажлын хэсгийн саналыг Материаллаг байдал ба цар хүрээг тодорхойлох дээр сонсох.

Г.Ганбат – Бидний бодлоор сонгогдох 155 компаниудаас бүтээгдэхүүн олборлосон компаниудыг заавал сонгох ёстой юм. Олборлолт хийсэн мөртлөө татвар нь бага компаниуд хасагдаад явчих вий?

Н.Эрдэнэцог – Бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн гээд 160-аад компани байгаа.

Өнөөдрийн байдлаар Засгийн газрын тайлан дээр 1924 компани сонгогдсон. Сангийн яам, БОЯ /50% төвлөрүүлсэн сан/, Хөдөлмөрийн яам, Мэргэжлийн хяналт /торгууль/ тайлангаа өгөөгүй байгаа. Орон нутгаас Багануур, Баянзүрх дүүрэг, Өвөрхангай, Ховд, аймгууд тайлангаа өгөөгүй. Өнөөдрийн байдлаар 670 компани тайлангаа гаргасан байна. 670 компанийн нийт үндсэн мэдээлэл 750 тэрбум орчим төгрөг болж байна лээ. Засгийн газрын хувьд 1,5 их наяд байгаа.

Н.Эрдэнэцог: Би БОЯ-ны энэ асуудлыг хариуцсан хүнтэй утсаар ярьсан. Өнгөрсөн жилийн тайланд нөхөн сэргээлттэй нөөцийн компаниудын төвлөрүүлдэг 50%-ийг энэ жил хамруулахгүй байхаар шийдсэн үү гүй юу.

Г.Ганбат: БОЯ ганцхан тэр төлбөрийг тайлагнадаг. Маягт дээрээ байдгаараа байгаа. Ашиглалтын лицензтэй компаниуд яаманд төлдөг, хайгуулын лицензтэй компаниуд суманд төлдөг. Сангийн яамнаас төрийн өмчийн ногдол ашгийн мэдээлэл ирдэг. Хөдөлмөрийн яамнаас гадаадын мэргэжилтэн ажилчдын мэдээлэл, МХГ-аас торгууль ирдэг.

Н.Эрдэнэцог: БОЯ-ны хүн өнгөрсөн жилээс хойш тайланд хамруулахгүй байхаар шийдсэн. Нууц мэдээлэлд хамруулна гэсэн асуудал ярьж байна лээ. Тэгвэл тийм асуудал гараагүйн байна тэ?

Н.Баярсайхан: Байгаль орчны нөхөн сэргээлттэй барьцаа хөрөнгийн төвлөрсөн болон буцаан олголтын мэдээ нууц байх ёсгүй шүү дээ. Харин ч ил тод байх ёстой. Ашиглалтын лицензтэй компаниудаас хэдий хэмжээний нөхөн сэргээлттэй барьцаа цугласан. Тэрний хэд нь нөхөн сэргээлтээ хийгдээд, буцаан олгогдсон юм, одоо үлдэгдэл байгаа юмуу байхгүй юмуу гэдэг дээр хаалттай байгаа. Өнгөрсөн жилийн тайланд 2014 оны нөхөн сэргээлттэй барьцаа 50% төвлөрүүлсэн сангийн 2.3 тэрбум төгрөг цугларсан мэдээ байсан. Тэрний зарцуулалтыг тодорхой болгох хэрэгтэй. Харин ч энэ сангийн орлого, зарцуулалт ил тод байх ёстой.

Н.Эрдэнэцог: За ойлголоо. Семинарын саналууд эхний тайлан дээр тусгагдаад явна.

Н.Баярсайхан: Нэг юм бас асууя. Сайн дурын төлбөрийг маягтаар аваад, тулгалт хийхгүй гэж танилцуулгаас ойлголоо зөв үү.

Н.Эрдэнэцог: Тиймээ. Яагаад гэвэл ажлын даалгавар дээр ч тэр заасан байгаа.

Н.Баярсайхан: Тэгэхээр энийг нэгтгэл тайланд харуулахдаа, голдуу энэ чинь хандив, дэмжлэг яваад байгаа шдээ. Тийм учраас нэр устай нь, нэрээр нь, зориулалтаар нь гаргая гэдэг саналтай байна. Үүнийг өнгөрсөн жил түүний өмнө ч хэлж санал гаргаж ирсэн. Зарим нь тэгж гарсан, зарим нь гаргаагүй. Жишээлбэл, 2014 оны нэгтгэл тайланд Орхон аймагт гэхэд Эрдэнэт үйлдвэр 450 сая төгрөг ТББ-т өгсөн гэж тайлагнасан байгаан. Нэг ТББ-т өгсөн юмуу, нилээд хэдэн ТББ-д өгсөн юмуу, эсвэл өөрийнхөө дэргэдэх үйлдвэрчний эвлэлд өгсөнөө хэлээд байгаа юмуу, 450 сая төгрөг эзэнгүй болчоод байгаа. Үүний цаана юу байна гэхээр иргэний нийгмийнхэн компаниудаас мөнгө авдаг гэж ойлгогддог. Тийм учраас үүнийг нэр, усаар нь хэн, хаанаас, ямар зориулалтаар авсаныг баталгаажуулж, тайланд оруулах хэрэгтэй. Зарим нь ч магадгүй нөхөн олговор өгснийгөө, сайн дурын компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд зарим нэгэн үйл ажиллагаа явуулсаныгаа ч гэсэн энд оруулчихаад байгаа. Тэгэхээр үүний ялгаа заагийг гаргаж харуулах хэрэгтэй.

Д.Төр-Од: Нөгөөтэйгээр ийм асуудал байгаамаа. Үүнийг яагаад тулгалт хийх шаардлагатай вэ гэхээр сайн дурын гээд байгаа нь ихэнх нь хандив, ялангуяа орон нутагт хандив, тусламж нь авилгалын шинж чанартай зүйлүүд яваад байгаа. Яагаад гэвэл өмнөх жилүүдэд юу харагдсан гэвэл ялангуяа Засаг дарга нар дэргэдээ юмуу, эсвэл найз нөхөд, хамаатан садны шугмаар ийм иргэний нийгэм юмуу эсвэл орон нутгийн ТББ байгуулаад, тийшээгээ хандив нэрийдлээр санхүүжилт аваад байгаа. Өөрөөр хэлбэл, орон нутагт авилгалыг бий болгох, дэмжих хэрэгсэл болчихоод байгаа. Тийм учраас тулгалт хийгээд, олон нийтэд нээлттэй болгох нь чухал болоод байгаа юм.

Н.Баярсайхан: Орон нутгийн засаг дарга нар бол хэлж байгаа. Бид нар төсвийн тухай хуулиар бол хандив авч болно оо, ашиг сонирхлын тухай хуулиар авч болохгүй, хүсч ч болохгүй гэж байгаа. Тэгэхээр орон нутгийн засаг дарга нар юу гэж байна гэхээр, бид нар ТББ байгуулаад, эсвэл байгаа ТББ-р дамжуулаад ялангуяа залуучуудын, эмэгтэйчүүдийн, ахмад настангуудын дансаар дамжуулаад энэ бүгдийг зохицуулж байгаа, компанитайгаа тохирч байгаа гэж ярьж байгаа. Тийм учраас энийг зайлшгүй зориулалтаар нь нэр устай нь харуулаад, зарим томоохон хандивуудад тулгалт хийх хэрэгтэй. ТББ-с нь асуугаад ямар зориулалтаар авсныг тодруулах ёстой. Компани буруу тайлагнасан байж болно. Баахан бичиг цаас, ном, сурах бичиг, хөнжил гудас өгчихөөд тэрийгээ хандив гээд тайлагнасан байж болно. Тэгэхээр бид нар хандивын чанарыг шалгах ёстой. Тийм учраас тулгалт хийх хэрэгтэй, тодорхой болгох хэрэгтэй байгаа. МэдээжхХувь хүнийнхийг бол тулгалт хийх боломжгүй, бага дүнтэй тул орхиход болохгүй юмгүй.

Н.Эрдэнэцог: Тэгэхээр Төрийн байгууллагуудад өгсөн хандив бол заавал гаргах ёстой, гараад ирнэ. Сайн дурынх гэж яагаад хэлээд байна гэхээр ТББ-уудад бид нар хандах болж байна. Тэгэхлээр яахав бид нар компанийн мэдээлэл дээр л үндэслэнэ, тэгэхлээр тэрний мэдээллийн үнэн зөв байдлыг заавал тодруулах шаардлагатай болж байна тийм үү. Тэгэхээр нэг тамирчин юмуу, нэг оюутанд сургалтын төлбөр өгчихвөл тэр оюутантай уулзана гэж байхгүй ш дээ ер нь.

Н.Баярсайхан: Тэхдээ хувь хүнийх бол ондоо байхгүй юу. Бага дүнтэй, эмчилгээний зардал л өндөр харагдах байх, харин нөхөн төлбөр өгснөө хувь хүнд өгсөн дэмжлэг хандив гэж тайлагнах магадлалтай учраас өндөр дүнг тодруулах шаардлагатай л гэж хэлээд байгаа юм.

Н.Эрдэнэцог: Компаниуд бүхий л хандиваа гаргаад ирдэг. Хувь хүн, ТББ, найр наадам гэх мэт.

Н.Баярсайхан: Хувь хүнийг бол орхичих хэрэгтэй. Тэхдээ томоохонуудыг бас авч үзэх шаардлагатай.

Н.Эрдэнэцог: Тэгэхээр сайн дурын гэдэгт ямар ямар юмнуудыг тулгах ёстой гэдгийг нарийн тохиролцёе тиймээ. Энэ дээр та бүхэнд Эхлэлийн тайлангийн драфтыг гишүүдэд явуулна. Тэрэн дээр энэ саналаа оруулна уу.

Н.Баярсайхан: Тэгье.

Н.Эрдэнэцог тайланд орох суурь мэдээллүүдийн талаар танилцуулав.

Хууль эрх зүйн орчны талаар оруулаад байя гэвэл маш их мэдээлэл байгаа. Яг тайлагнах зохистой хэмжээ нь ямар байхын, нөгөө тайлан маань хэр зэрэг зузаан болох уу, оруулахгүй орхигдуулчихвал яах уу гэх мэт асуудлууд байгаан. Тэгэхээр энэ дээр яг гол гол хуулиуд нь юу байх ёстойн гэдэгээ нарийн тодорхойлох ёстой байх гэж бодож байгаа.

Д.Эрдэнэчимэг: Олборлох салбарын эрх зүйн орчин гэхээр ямар ямар хуулиуд хамаарах бол? Тухайн хуулиудын зохицуулалтыг харахад тухайлан олборлох салбарт хамаарахгүй ч гэсэн нийгмийн бүх салбарт хамаарна. Тэхдээ олборлох салбарын шийдвэр гаргалтанд гол гол нөлөө үзүүлэхүйц хуулиуд 2015 онд батлагдаж, хэрэгжиж эхэлсэн. Яг олборлох салбарын эрх зүйн зохицуулалт гээд орчихоор тэр юмнууд нь орхигдчих вий гэж санагдаад байгаа. Тэр нь юу гэвэл тухайлбал, захиргааны ерөнхий хууль байхад захиргааны бүх шатны шийдвэр гаргалт гаргалтыг зохицуулж өгсөн байгаа. Тэгэхлээр тусгай зөвшөөрөл олгохоос эхлээд, усны зөвшөөрөл гэх мэт уул уурхайн салбарт гарч байгаа бүх шийдвэрт энэ хууль яалтчгүй нөлөө үзүүлнэ. Мөн Хууль тогтоомжийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн байгаа. Захиргааны хэргийг шийдвэрлэх тухай хууль гэж гарсан байгаа. Энэ дээр олборлох салбартай юугаараа холбоотой вэ гэхээр байгаль орчин, уул уурхай, газар ашиглалт гэх мэт нийтийн эрх ашгийн асуудлууд үүсдэг. Тэгэхээр Иргэний нийгмийн байгууллагууд иргэдээс нийтийн эрх ашгийн асуудлаар нэхэмжлэл гаргах эрхийг олгосон ч гэдэг ч юмуу яг хуулийг нь харах юм бол нийгмийн бүх салбарт хамаарах ч гэсэн, олборлох салбарт нөлөөлөх хэд хэдэн хуулиуд шинээр батлагдаж, бий болсон байгаа. Энийг орхигдуулах вий гэсэн болгоомжлал байна. Дээрээс нь Эрдэс баялгийн салбарын ил тодын тухай хуулийн төсөл маань гарахгүй удаан дуншиж байна. Энэ дээр цаашдаа энэ хуулиа 2015 онд ямар өөрчлөлт дэвшилт гарсан, цаашдаа энэ хуулиа батлах талаар төр засгийн бодлого, чиг хандлага нь ямар байгаа талаар, гэрээний ил тодын асуудал 2014 оноос яригдаад нилээд эрчимтэй явагдаж байгаа, Бенефициар өмчлөгчийн асуудал 2016 онд батлагдсан шинэ стандартаар 2020 онд хэрэгжиж эхлэх ч гэсэн ерөнхийдөө энийг хэрэгжүүлж эхлэхтэй холбоотой суурь боломж, сорилт нь юу байна гэдгийг хараад, дүгнээд явчих юм бол зүгээр байна.

Н.Эрдэнэцог: Олборлох салбарын эдийн засагт оруулсан хувь нэмрийн талаар тайланд хэрхэн тусгах талаар танилцуулав.

Ноднин бол бичил уурхайтай холбоотой тоон мэдээллийг тодруулах хэрэгтэй байна гэж Ажлын хэсгээс санал гарч байсан юм билээ. Боломжтой бол үүнийг энэ жилийн тайланд оруулах бодолтой байгаа. Энэ дээр ажлын хэсгийн санал байна уу?

Н.Баярсайхан: Бичил уурхайн талаарх мэдээллийг хаанаас авах вэ?

Н.Эрдэнэцог: Бичил уурхайн талаарх мэдээллийг ерөнхийд нь нэгтгэдэг Төрийн байгууллага гэж байдгийн болов уу? Бичил уурхай чинь голцуу алт биз дээ тэ. Жонш бас байгаа.

Н.Баярсайхан: Ашигт малтмалын газарт Бичил уурхай эрхлэгчдийн хэлтэс байгаа. БОЯ дээр бүртгэлтэй нөхөн сэргээлтийн 250 компани байгаа. Тэд нар Монголбанкинд тушаах үүрэгтэй. Тэд нараас мэдээлэл авч чадах нуу. Жоншны нийт экспортын 80%-ийг гар аргаар боловсруулсан жонш эзэлдэг гээд байгаа. Тэгэхээр багагүй мэдээлэл гарахаар байгаа.

Н.Эрдэнэцог: Тэгэхээр жоншны гол олборлолтыг хаанаас хийж байна, тэр аймгуудаас, аль сум гэдгийг нь тодорхойлж байгаад, тэр сумынх нь холбогдох төрийн байгууллагаас авч магадгүй.

Н.Баярсайхан: Гаалиас бас экспортын мэдээлэл авч болно.

Н.Эрдэнэцог: Гаалиас бас авч болно. Тэхдээ тэр мэдээлэл нь ямар хэлбэрээр гарч байна.

Н.Баярсайхан: Гэхдээ тэр жоншийг бичил уурхай эрхлэгчдээс худалдаж авах эрх нь лицензтэй компаниуд байгаа. Тэр компаниудын мэдээлэл энд ирж үү. Эцсийн мэдээг гаалиас авах байх.

Н.Эрдэнэцог: Гааль дээр яг тэр олборлогчоос гаалиар гарсан байна уу гэдэг нь тодорхойгүй.

Н.Баярсайхан: Дорноговийн Хар айраг дээр гол зангилаа байгаа. Тэгэхээр тэр хавиас мэдээлэл нь олддог юм болов уу. Чухам баталгаатай эх сурвалж нь юу байж болох бол гэж гайхаад асуугаад байна.

Н.Эрдэнэцог: Харин тийм. Энэ дээр та бүхнээс бас санал авмаар байна. Боломжтой бол иймэрхүү иймэрхүү байдлаар явдаг гэсэн саналаа биччихвэл энэ чиглэлээр нь бид нар хайя, хамгийн боломжтой хувилбараар нь олон талаас нь үзэж байгаад аль болох, ямар л мэдээлэл цуглана, тэрийг нь ил болгоё гэж бодож байна.

Н.Эрдэнэцог: Тайланд тусгагдах үйлдвэрлэл, экспортын талаарх мэдээллийг танилцуулав. Үндсэн ашигт малтмал гэдэг дээр ямар ашигт малтмалуудыг хамруулах ёстой вэ? 15 ашигт малтмалаа үндсэн гэж үзээд, үлдсэнийг нь бусад гэж үзэх үү. Мэдээллийг гаргахдаа ямар хэлбэрээр тавих вэ. Эдгээрийг холбогдох төрийн байгууллагуудаас мэдээллийг нь авч тодруулах болов уу гэж бодож байна.

Н.Эрдэнэцог: Дараагийнх нь олборлох салбар дахь төрийн оролцооны талаарх мэдээлэл.

Г.Ганбат: Энэ дээр өнгөрсөн жил яригдаж байсан нэг санал байна. Жишээ нь: Өмнө жил Эрдэнэт үйлдвэрийн ногдол ашгийг Засгийн газар хүссэн үедээ авчихдаг гэсэн асуудал яригдаж байсан. Тэр талаар ямархуу практик байгаа, уг нь яаж зохицуулах ёстой вэ гэдгийг оруулбал зүгээр.

Д.Эрдэнэчимэг санал: Яг энэ асуудлаар шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт Туршилтын баталгаажуулалтын тайлангаар авсан. Тэр Туршилтын баталгаажуулалтын тайланд яг юу нь тодорхой болохгүй байгаа юм гэсэн бичсэн байгаа. Юун дээр болохгүй, алдаа дутагдалтай байгаа талаар тайлан дээр тодорхой гарц нь байгаа учир тэр туршилтын тайланг сайн судлах хэрэгтэй.

Н.Эрдэнэцог: Олборлох салбараас олсон орлогын хуваарилалтын талаар танилцуулав.

Улсын төсөвт олборлох салбараас төвлөрүүлсэн орлогыг ил тод болгох, бүртгээгүй байж болох орлогыг мэдээлэх гэж байгаа. Бүртгээгүй байж болох ямар орлого байж болох вэ? Энэ дээр Монгол улсын хувьд ямар кейсүүд байж болох уу гэдэг дээр та бүхний саналыг сонсмоор байна.

Н.Баярсайхан: Танайх өөрсдөө дэвшүүлсэн санал юм шиг байна тэ.

Н.Эрдэнэцог: Гол нь та бүхний саналыг сонсмоор байна. Бид нар бол бүртгээгүй байж болох ямар орлого байж болох вэ гэдэг дээр та бүхний саналыг сонсож байгаан.

Н.Баярсайхан: Тэгвэл ийм юм орох болов уу гэж бодож байна. Ирээдүйд авах татварыг одоо авчихаад бүртгэхгүй яваад байгаа, өр гэж харагдаад байгаа. Бас нэг юм нь Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээд, хуваарилахдаа дунд нь яг мөргөж байна уу гэдгийг шалгах хэрэгтэй. Өнгөрсөн жил ихэнх аймаг, сумууд нь аваагүй. Баахан ажил гүйцэтгэсэн, гэвч мөнгийг нь аваагүй компани олон байсан. Энэ тохиолдолд мөнгө нь бүрэн шилжигдсэн үү гэдгийг шалгана. Борнуур сум гэхэд л ерөөсөө аваагүй. Аймгийн дарга өөр нам учраас Борнуур суманд 30%-ийг нь өгөөгүй. Тэгэхээр иймэрхүү юмнууд дундаа хийдэгдээд, Сангийн яамнаас шилжүүлээд аймагт өгсөн боловч аймаг нь цаашаа сумандаа өгөөгүй байх магадлалтай.

Н.Эрдэнэцог: Энэ нэмэлт мэдээллийн 5.2-т материаллаг байдал, орон нутагт шилжүүлсэн шилжүүлэг гэсэн тусдаа шаардлага байгаа. Энэ бол тэр лүү орох юм байна л даа. Энэ хойшоо яригдаад явна.

Н.Баярсайхан: Тусгай сангууд байгаа шүү дээ.Дандаа уул уурхайн салбарын орлогоос эх үүсвэртэй байгуулагдсан сангууд. Энэ тусгай сангуудын мөнгө шилжсэн байдал. Сангийн яам дотроо яаж гүйлгээ хийгээд байдгийн, тэр хүүхдийн мөнгө олгож байгаа чинь халамжийн сан руу явчихаж байгаа юу?Ойлгомжгүй сангууд байна. Хүний хөгжлийн сан, тогтвортой байдлын сан зэргийн мөнгөн урсгал нь яаж явдаг нь тодорхойгүй байна.

Н.Эрдэнэцог: Энэ сангуудын тайланг Сангийн яамнаас бид нарт гаргаж өгөх үү?

Н.Баярсайхан: Өгөх ёстой гэж бодож байна. Нээлттэй л байх ёстой ш дээ.

Н.Эрдэнэцог: Энэ орлогын менежмент, зарцуулалтын талаар гээд шаардлагатай холбоотой юм байна.

Н.Баярсайхан: Ирээдүйн өв сангийн тухай хууль өнгөрсөн жил батлагдсан. Тэгэхээр Ирээдүй өв сангийн тухай хууль хэрэгжихэд энэ олон сангууд нь яаж зохицуулагдах юм, хумигдах юмуу, Энэ санд мөнгө төвлөрүүлэх, энэ хуулийг хэрэгжүүлэх бололцоо нь хэр байгаад дүгнэлт хийчихвэл хууль эрх зүйн орчин дээрээ дүгнэлт хийвэл зүгээр. Энэ талаар боломжоороо судлаад оруулах боломж байна уу. Танайх хуульчтай гэж бодож байна. Учир нь бид ОУИТБС-ын хүрээнд өнгөрсөн жилийн мэдээллийг боловсруулж тайлан гаргах гээд байгаа нь 2015 онд МУ-ын эрдэс баялгийн салбар ямар байсныг түүх болгож бичих гээд байна. Тийм учраас саналууд гаргаад байна.

Н.Эрдэнэцог: Лиценз олгох явц, бүртгэлийн талаар танилцуулав.

Б.Батболд: Энэ дээр та нарын нэг санал байгаа юм байна. Хүсэлт гаргасан огноо, координатыг ил тод болгоно гэж байна. Жишээ нь: Иргэн Дорж хүсэлт гаргавал тэр хүсэлт нь ил болох нь байна. 2 дугаарт координат нь ил болно. Хувиараа ашигт малтмал олборлогч чинь нь координатыг нь мэдэж аваад, тэр координат дээр нь очиж хайгуул хийж, ухах юм биш биздээ.

Г.Ганбат: АМГ Координатыг ил тод болгож байгаа. Лицензийг өргөдлөөр олгож байсан. Хүсэлт гаргасан хүн нь байгаа.

Д.Эрдэнэчимэг: Туршилтын баталгаажуулалтын тайлангаар Тусгай зөвшөөрөл олгож байгаа процессоо олгоод сайн бичиж, гэвч процесс олголт нь үр дүнтэй байгаа эсэх, цоорхой, асуудал үүсэх эрсдэл юу байна гэдгийг дүгнээгүй байна гэсэн. Гомдол гараад байгаа асуудлыг тодруулах, яагаад гомдол гаргаад байгаад дүгнэлт өгөх нь учир дутагдалтай гэсэн байгаа.

Б.Батболд: Нэг санал байна. Олон улсын хурал дээр явж байхад гайхаад байсан. Жишээлбэл, манай тайланг аваад үзэхэд ийм журмаар зөвшөөрөл олгоноо гэж байдаг. Тэхдээ журмыг нь үзье гэхээр байдаггүй. Тэхдээ журмыг нь мэдэхгүй яахын бэ гэхээр линкийг нь заагаад өгчихдөг баймаар юм биш үү гээд байгаа. Тэгэхээр бид нар бас линкийг нь оруулчихвал зүгээр юм билээ л дээ.

Ш.Цолмон: Хамгийн гол нь линк нь байгаа. Тэхдээ линк рүү нь орохоор тэр мэдээлэл нь байхгүй байх тал байдаг. Тэрийг давхар шалгах ёстой.

Н.Эрдэнэцог: Тэгэхээр манайх линк оруулаад, тодорхой хугацааны дараа тэр веб сайт нь хаагддаг ч юмуу, хөгжүүлэлт энэ тэр хийгээд зам нь өөр болсон байхыг үгүйсгэхгүй.

Д.Эрдэнэчимэг:Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгож байгаа процессийг тайланд оруулж өгөх. Өмнө жил түгээмэл тархацтай ашигт малтмал орж байгаагүй.

Н.Баярсайхан:Ураны лиценз орохгүй байгаад байна. Мөн газрын тосны лицензийг оруулж өгөх. Өнгөрсөн жилүүдэд ороогүй. Хүсэлт гаргасан огноо, координатыг ил болгохоос гадна, лицензийн хөдөлгөөнийг ил болгох хэрэгтэй байна. Өнгөрсөн 2015 онд хэдэн компани лицензийг буцааж шилжүүлсэн юм. Хоорондоо зарсан юм, цуцалсан юм? Одоо АМГ дээр мэдээлэл нь ирсэн байгаа. Энэ дээр линк заахгүйгээр

жилийн нэгдсэн хэмжээгээр орох ёстой. Дараа нь судалгаа хийхэд хэрэгтэй. Учир нь 2015 оны уул уурхайн салбар ямар байсан талаарх мэдээлэл бичигдэж байгаа.

Г.Ганбат: Лиценз олголт 2 аргаар явж байгаа. Өргөдлөөр явж байгаа нь онлайнаар хүсэлт гаргаад арай нээлттэй. Харин тендерээр явж байгаа нь асуудал үүсгэдэг гэж гомдол их гардаг. Энэ дээр журам нь яаж явдагийг тодорхой болгох тухай оруулах.

Н.Эрдэнэцог: Эцсийн үр шим хүртэгч буюу бенефициар өмчлөгчийн тухай.

Ш.Цолмон: Өнгөрсөн жил хууль ёсны хувьцаа эзэмшигч гэдэг утгаараа гарсан. Одоо бол ашиг хүртэгч эзэд буюу яг бенефициар гэдэг ойлголтоор ажлын дэд хэсэг гарчихаад судалгаа хийгээд явж байгаа. Одоо 24, 25-нд Байгалийн баялагийн засаглалын хүрээлэнтэй хамтраад сургалт зохион байгуулна. Замын зураг гээд төлөвлөгөө гаргах ёстой. Тусдаа ажил явагдана. Түүнтэй байнгын холбоотой явагдана гэж ойлгож байгаа. Та хэд компаниуд руу маягтаа явуулдагаараа явуулна. Тэр хооронд бид ашиг хүртэгч эзэд, улс төрийн хувьд нөлөө бүхий гэдэг ч юмуу тиймэрхүү нэр томъёо гарах ёстой. Тэрийг яаж хэрэгжүүлэх талаар 2017 онд замын зураг гэж юм гаргах ёстой.

Н.Баярсайхан: Шаардлагаар тендерт оролцсон, хөрөнгө оруулалт хийсэн бүх компаниудын хувьд гэж байгаа боловч танайх зөвхөн сонгогдсон компаниудын хүрээнд гэж оруулсан нь учир дутагдалтай байна. Тэгэхээр Ш.Цолмонгийн хэлдэгээр судалгаа хийгдэж байгаа юм байна, тодруулах, тайланд оруулах хэсэг нь арай өргөжих юм байна.

Д.Эрдэнэчимэг: Судалгаа хийгдэж байгаа. Судалгаан дээрээ эрх зүйн орчин, боломж, сорилт, болохгүй байгаа асуудал, ашиглаж болох тогтолцоо г.м Бенефициар өмчлөгч гэж юу байна, ямар компаниудыг хамруулах уу, стандарт нь юу байна гээд санал болгож байна. Ажлын хэсэг маань судалгаанд үндэслээд нэгдсэн байр сууринд хүрнэ. Үндэсний хэмжээнд Бенефициар өмчлөгч ингэж ойлгоё, ийм компаниудыг хамруулая, үүнтэй холбоотой ийм мэдээллүүдийг хамруулъя гэдэгт хүрэх нэгдсэн байр суурийн эхний хэлэлцүүлэг нь 2016.08.24, 25-нд болно.

Н.Эрдэнэцог: Энэ семинарт оролцож болно биздээ.

Ш.Цолмон: Боллолгүй яахав.

Н.Баярсайхан: Тэхдээ танай гадны зөвлөхүүд чинь энэ талаар сайн мэдэж байгаа байлгүй дээ. Энд гадны зөвлөхүүд чинь их оролцоотой байх хэрэгтэй байна.

Н.Эрдэнэцог: Гэрээний талаарх ил тод байлгах.

Ш.Цолмон: Гэрээний ил тод байдлын хүрээнд Уул уурхайн яамтай хамтраад санамж бичиг байгуулах ёстой. Одоо чинь гэрээний ил тод байдлын веб сайт ажиллуулж эхэлж байгаа. Тэрний хүрээнд үүнийг цаашид яаж баяжуулах уу гэх мэтээр холбогдсон үйл ажиллагааны талаар 2015 оны тайланд орох ёстой. 2015 онд нилээд судалгаа хийгдсэн байгаа. Гэрээний үнэлгээнүүд явагдаж байгаа. Тэгэхээр Уул уурхайн яамнаас мэдээлэл авна.

Н.Эрдэнэцог: Гэрээний ил болгох асуудал тайлангууд дээр жагсаалтууд яваад байдаг. Ижил төстэй гэрээнүүд байвал гол заалтуудыг оруулдаг ч юмуу. Энийг

зохистой байдлаар, хэрхэн ил тод болгох ёстой вэ гээд, гэрээ чинь асар их бичвэртэй, тайланг зузаан болгох асуудал байна. Сайт байвал линкийг нь зааж өгнө.

Д.Эрдэнэчимэг:Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан гэж хийгдэж байгаа. Тэрэн дээр бүх гэрээнүүд текстээрээ ил тод болох ёстой. Уул уурхайн яам, ажлын алба, иргэний нийгмийн байгууллагуудын хооронд урьдчилсан тохиролцоо хийгдээд, мэдээллийн сан үүсэх ажил эхэлсэн. Одоо мэдээллийн сан нь бий болоод, гэрээнүүдээ татаад байршуулах гэхээр Уул уурхайн яам дээр ухралт гарсан бололтой, гэрээнүүдээ ил болгохгүй байгаа. Тухайлбал, газрын тосны гэрээ ил болохоор болсон боловч тэрнээс хойш байгуулагдсан 3 гэрээгээ өгөөгүй байгаа. Гэх мэтчилэн туршилтын баталгаажуулалтын тайлан дээрх төрийн бодлого нь одоо болтол тодорхой биш байна. Хийгдсэн тохиролцоо, хурал семинар нь хийгдээд байгаа боловч бодлого болж гараагүй учраас хэрэгжихгүй байгаа гэсэн байсан. Тэрийг бодлогын талаас нь, эрх зүйн талаас нь дүгнэж өгөөд, одоо явж байгаа процессийг нь дурьдаад, гэрээнийхээ хийгдэж байгаа сайтны линкийг тавьчихвал болох юм.

Ш.Цолмон: Тэгээд бас Орон нутгийн гэрээний маягт гарсан. Энэ дээр Засгийн газрын тогтоол гарсан. Тэрийг бас оруулах ёстой.

Д.Эрдэнэчимэг: Гэрээний маягттай холбоотойгоор Дорнод аймгийн Хамтын ажиллагааны гэрээний загвар шинээр батлагдсан. Яг тэр загвар гэрээ дотор ил тод байдал, орон нутгийн иргэдийн оролцоотой холбоотой нилээд тодорхой ахиц, дэвшилттэй зохицуулалтууд орсон учир тэрийг бас дурьдаад өгвөл зүгээр.

Н.Баярсайхан: Тэгээд Н.Эрдэнэцогоос ийм юм гараад байна. Тайланг зузаан болчих бай гэсэн зовинол удаа дараа гараад байна. Үүнээс айх хэрэггүй. Тайлангаа ямар ч байсан хангалттай хэмжээгээр болгочихоё. Тэгээд хураангуй тайланг хэвлээд, бусдыг софтоор хавсралтаар өгөх ажил байж болно. Харин удаа дараа гаргаж байгаа хүсэлт байна. Тайланг аймаг аймгаар нь, ядаж бүсчилээд хангайн, говийн бүсийн гэх мэт хийгээд өгөөч гэж хүсмээр байна. Анхнаасаа мэдээллээ цуглуулахдаа аймаг аймгаар нь авч байгаа шүү дээ. Дахин хэлэхэд тайлан зузаан болно гэж айхгүйгээр яваачээ. Яагаад гэвэл стандарт шаардлага чинь өмнө нь 2 талын тоог нь л мөргүүлдэг байсан бол одоо илүү өргөжсөн байгаа. Тэгэхээр тайлан зузаан болох нь ойлгомжтой. Тэрийгээ гаргахдаа хэлбэрийн хувьд хэдүүлээ дараа нь ярьж болно ш дээ.

Д.Эрдэнэчимэг: Тайланг өөрийг нь харахаар үндсэн мэдээлэл нь нээх зай авдаггүй, хойд талын хавсралтууд, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт нь ихэнх хуудсыг эзэлж байна. Тиймэрхүү эх үүсвэр нь байгаа юмнуудыг бид нар цаасан дээр хэвлэж оруулахгүй байж болно ш дээ.

Захиргааны ерөнхий хууль батлагдсан. Энэ дээр захиргааны гэрээ гэж шинэ ойлголт орж ирсэн. Төрийн байгууллагаас, нийтийн захиргааны байгууллагаас чиг үүргээ хэрэгжүүлэхдээ байгуулж байгаа бүх төрлийн гэрээг захиргааны гэрээ гэнэ гээд захиргааны гэрээ байгуулах процессийг нь зааж өгөөд, тухайн гэрээний улмаас эрх ашиг нь хөндөгдөж байгаа талуудын оролцоог хангана гэсэн тийм заалтууд орсон. Энэ захиргааны гэрээ гэдэг ойлголтод уул уурхайн салбарт байгуулагдаж байгаа ямар ямар гэрээнүүд хамарч орох вэ гэдэг дээр хуульч байгаа бол дүгнэлт хийж өгмөөр байна. Иргэний нийгмийн байгууллагууд, би ч бас хуульч хүн үзэхээр манай

бүх гэрээнүүд бол хамарч орохоор хуулийн зохицуулалт нь харагдаад байгаа. Тэгэхээр энэ эргэлзээтэй байгаа. Хууль зүйн хэсэг дээр оруулж өгөх нь байна.

Н.Баярсайхан: 2016 оны дундуур батлагдсан хууль эрх зүйн орчны талаар мэдээллийг оруулж өгөх нь зүйтэй. Хэдийгээр 2015 оны мэдээллийг хамарч байгаа ч гэсэн 2016 оны салбарын шинэтгэл, шинэ соргог мэдээллүүдийг оруулж өгөх нь зүйтэй байх.

Н.Эрдэнэцог: Хамрах хүрээний хувьд одоо тайлан оны эцэс рүү гарахад 2015 он биш 2016 оноо бас оруулна гэсэн үг үү.

Н.Баярсайхан: Тэхдээ 2016 оны эцэст гарах юм чинь эрх зүйн орчин дээр 2016 оны процессийг оруулж өгөхөд болохгүй юмгүй байх.

Түр завсарлага авав.

Н.Эрдэнэцог: Ил тод болгох шаардлагатай нэмэлт мэдээллүүдийн талаар танилцуулав.

Шаардлага 4.2-ийн дагуу үйлдвэрлэлээс төрд ноогдох хувь хэмжээг зарж борлуулах эсвэл бэлэн бус байдлаар олсон бусад орлого.

Г.Ганбат: Газрын тосны бүтээгдэхүүний хуваах гэрээ эндордог. Газрын тосноос Засгийн газарт ногдох орлого гээд байдагв. Тэр л ерөнхийдөө ордог. Тэрнээс гадна нүүрс ордог. Улс орон өөрөө газрын тосоо тосоор нь авсан уу, зарсан мөнгөөр нь авсан уу гэдгийг тодруулах ёстой. Ерөнхийдөө Монголд газрын тосны хувьд дандаа мөнгөөр нь авдаг. Бусад нүүрс дээр яадаг юм бол.

Наранцэцэг: 2 багийн иргэдэд өвлийн улиралд 2 тонн нүүрс өгдөг. Тэрний төлбөр мөнгө нь яаж ордогийн бол. Бэлнээр ордогийн болов уу хандиваар ордогийн болов уу гэдгийг тодруулах ёстой.

Н.Баярсайхан: Багануурын жишээ байна. Нүүрсийг газраас олборлох өртөг нь 27500 төгрөг, ДЦС-уудад 22000 төгрөгөөр өгдөг. 5500 төгрөгийн алдагдлыг төр үүрдэг. Тэгэхээр Багануур ашиггүй ажилладаг.

2-рт ногдол ашиг хуримтлагдаж байтал Засгийн газар хэрэгцээтэй үедээ шууд татаад авдаг. Тэгэхээр Эрдэнэт үйлдвэр 2015 онд хэдий хэмжээний ногдол ашгийг бий болгосон юм, тэр нь яаж зарцуулагдсан юм гэсэн мэдээллийг харвал зүгээр. Одоо Эрдэнэт 100% Монголын эрх мэдэлд шилжлээ. Тэхдээ энэ бол та нарын хугацаанд хамаарахгүй. 2015 онд хэдий хэмжээний ногдол ашиг олж байсан, тэдний зарцуулалт, захиргааны зарцуулалтыг ил тод болгомоор байгаан. Тэрийг ил тод болгох хэрэгтэй байгаа юм.. р нь төрийн өмчит компаниудын захиргааны зардал, худалдан авалтын зардал, ногдол ашиг гэх мэтийг ил болгохоор хэдүүлээ санал болговол яах вэ гэсэн саналтай байна.

Тэгээд орон нутгийн өмчит уул уурхайн компаниуд байгаа. Тавантолгой, Хартарвагатай, Могойн гол гэх мэт орон нутгийн өмчит уул уурхайн компаниуд байж байна. Энэ компаниудын мөн ногдол ашиг, захиргааны зардал, худалдан авалтуудыг бас ингэж тоон дүнгээр нь ил болгоё. Сая орон нутгийн өмчит Тавантолгой 60 жилийн ойгоо хийлээ. Тэгсэн чинь ганцхан дуучныг аваачихад 5 сая төгрөг өгсөн мэдээлэл байна. Тэгэхээр үргүй зардал их гараад байна.

Ш.Цолмон: Төрийн өмчийн компаниудад явуулах нэмэлт мэдээллийн маягт дээрээ ногдол ашиг, захиргааны зардал, материаллаг хэмжээний бараа нийлүүлдэг компаниудын нэрсийн жагсаалт гэдгийг тодорхой болгоно.

Б.Батболд: Наадах чинь 5 сая төгрөгөөс дээших худалдан авалт нь шилэн дансаараа ил тод болчихож байгаа. Тийм юм чинь шилэн дансны линкийг заагаад өгье.

Н.Баярсайхан: Чиний зөв энэ чухал. Тэхдээ линк заана гэдэг чинь төрийн санах ой чинь бүтэц нь нэг салаад, нэг нийлээд байхаар санах ой байхгүй, устаад байна. Тиймээс бодитой юмыг бид нар хуулж аваад, файл үүсгэж байх ёстой. Тийм учраас линкийг заана гэдгийг тэр болгон зөвшөөрмөөргүй байгаад байгаа юм. Нээгээд, хаагаад, шинэ удирдлага ирээд веб сайт нь байхгүй болоод байна. Шилэн данс бол найдваргүй. Яагаад гэвэл бид нар Монголын 2015 оны уул уурхайн түүхийг бичиж байгаа учраас зайлшгүй татаж аваад файл үүсгэх ёстой. Тиймээс Төрийн өмчит компаниудад бэлтгэн нийлүүлэгчийн талаарх маягтыг нэмж оруулах, ажлын хэсгээр маягтыг батлая. Магадгүй хамгийн томоохон барааг нийлүүлсэн 3 компанийг ил болгож болно. Жишээлбэл, Оюу толгой дээр Баярцогтын компани гараад л ирэх ёстой. Бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа компанийг гаргаад ирвэл. Ингэж байж бид нар ашиг сонирхлын зөрчлийг гаргаж ирэх хэрэгтэй шүү дээ. Тайлан гаргаж байгаагийн гол юм чинь бодлого тодорхойлж байхад энийг ашиглая, эрсдэлийг бууруулъя гэдэг зүйл байгаа учраас бараа бүтээгдэхүүн нийлүүлж байгаа компанийн асуудлыг ил тод болгох асуудлыг бид нар гаргамаар байна.

Н.Эрдэнэцог: Энэ одоо бусад хууль журамтай зөрчилдөх юм байх уу?

Н.Баярсайхан: Байхгүй. Хэдүүлээ энэ ажлын хэсгээрээ зөвлөлдөөд л шийдвэрээ гаргаад л, маягтаа батлаад өгчихье. Зөвхөн төрийн өмчит компаниудын хувьд гаргана.

Ж.Батцэнгэл: Худалдан авалтын хувьд уул уурхайн тоног төхөөрөмж дээр жишээ нь 0,5 тэрбум төгрөгөөс дээших худалдан авалтыг ил тод болгох ч гэдэг юмуу, марк моделтэй нь тайлбар оруулах ёстой. Тэгэхгүй бол зардалаа айхтар өндөр өсгөдөг, тэгээд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр жоохон юм авдаг.

Н.Баярсайхан: Тэгээд тэр зардлын чинь 34%-ийг Монгол улс төлж байгаа гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энийг яаж ил болгох уу гэдгийг хэдүүлээ сайн тухтай ярилцая.

Н.Эрдэнэцог: Саяны ярьж байгаа асуудал стандартын шаардлагад хамрагдах нь зөв үү?

Н.Баярсайхан: Зөв.

Н.Эрдэнэцог: Хэрвээ энэ төрлийн мэдээлэл гаргах боломжгүй байгаа бол яагаад боломжгүй байгаа талаар шалтгаанаа бичээд, тэрнийхээ дагуу арга хэмжээ аваад, шийдвэр гаргаад явчихна гэсэн үг. Тиймээ.

Н.Баярсайхан: Саяхан НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Азийн сан хоёроос энэ МУ-ын эрдэс баялагийн салбар дахь авилгын эрсдлийн судалгаа хийсэн байна. Тэр судалгааг бас үзмээр юм шиг байна лээ. Уул уурхайн ямар үе шатан дээр авилгалын эрсдэл байна вэ гэдэг талаас нь судалсан. Тэрэн дээр энэ төрийн өмчит компаниудын засаглалын ил тод байдал хамгийн хангалтгүй байна. Хамгийн

авилгал байх эрсдэл, үр ашиггүй зардал байх эрсдэл энд байна гэж байсан. Тийм учраас энийг бид нар авч үзэх шаардлагатай.

Н.Эрдэнэцог: Дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба бартерын солилцоог ил тод болгох талаар танилцуулав. Энийг нэмэлт мэдээллийн маягтаар тодруулна.

Энэ дээр бол 2015 оны шинэ тутам мэдээллээ оруулна гэхээс өмнө нь байгуулагдаад одоо явж байгаа концессийн асуудлыг оруулахгүй биз дээ тэ?

Н.Баярсайхан: 2015 онд Энержи ресурс замаа концессийн гэрээгээр улсад хүлээлгэн өгсөн.

Д.Эрдэнэчимэг: Энэ дээр нэг ийм асуудал яригдаад байсан. Концессийн гэрээгээр компаниуд орон нутагт зам юмуу дэд бүтэц, эмнэлгийн барилга барьдаг. Тэгээд тэрийгээ нийгмийн хөрөнгө оруулалт гээд холилдуулаад тайлагначихдаг асуудал өмнөх тайлангууд дээр их гарсан. Энийг яаж нэг тийш нь болгож, жишээ нь концессийн дэд бүтцийн бартерын зохицуулалт гэдэгт бид юугаа оруулж ойлгох ёстой юм, нийгмийн сайн дурын болон дэд бүтэцтэй нийгмийн хөрөнгө оруулалт гэж ойлгох ёстой гэдэг зааг ялгааг нь сайн гаргаж өгөхгүй бол манай өмнөх тайлангууд дээр дандаа холилдсон, Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл нь нэгдсэн байр сууринд хүрээгүй байгаа гэсэн үг. Туршилтын баталгаажуулалтын тайлан дээр дурьдсан байгаа.

Н.Эрдэнэцог: Энэ дээр яахав ялгаатай нь жишээ нь, эмнэлэг сургуулийг барихад хөрөнгө оруулалт хийгээд, тэр нь нэг л удаа бариад өнгөрнө, концессийн гэрээгээр барьсан зам бол концессийн хугацаа нь дуусаагүй бол тэр компани ашиглаж л байгаа. Хэзээ төрд өгөхөөр заасан тэр хугацаандаа явж байгаа, зарим нь хугацаа нь дууссан, зарим нь дуусаагүй. Тэгэхээр концессоор үргэлжлээд явж байгааг яах ёстой вэ?

Д.Эрдэнэчимэг: Тэгэхээр энэ чинь хянан нэгтгэгчийн үүрэг биш, Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл өөрсдөө ойлголтоо нэгтгэхчээд яг ийм юманд энийг ингэж ойлгож тусгаарай гэдэг юмыг хэлэх ёстой юм билээ. Тэгээд ойлголтоо нэгтгэж чадахгүй яваад байна.

Н.Эрдэнэцог: Нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалтын хамралтын талаар ил тод болгоно. Заавал компанийн үүргийн дагуу хийж байгаа ажил уу, сайн дурын ажил уу гэдгийг тодорхой болгох ёстой. Хуулиар шаардсан нийгмийн шинжтэй хөрөнгө оруулалтууд байвал тэр хуулийн заалт, ишлэлийг тодорхой болгох ёстой. Монголд энэ хуулиар заасан шинжтэй хөрөнгө оруулалт юу байдаг бол?

Д.Эрдэнэчимэг: АМ-ын тухай хуулийн 42.1-р заасныг хандив гэж тайлагнадаг.

Ш.Цолмон: Компанид явуулах маягт дээр үүнийг ялгаж, салгах ёстой. Зааварчилгаа сайн өгөх хэрэгтэй.

Н.Эрдэнэцог: Тээврийн орлого гэж Монголд байдаг уу? Өмнөх тайлангуудад ийм юм ерөөсөө байхгүй. УБТЗ ийм ийм компаниуд юмаа тээвэрлүүлсний төлөө тэдэн төгрөг төлсөн байна гэж гаргаад өгчихвөл болно.

Н.Баярсайхан: Урьд жил ийм юм гарч байсан. АМГ борлуулалтын орлогын мэдээ гаргаж байгаа. Энэ компани тэдий хэмжээний бүтээгдэхүүн борлуулсан гээд. Гэтэл

Гаалийн ерөнхий газраас экспортын мэдээ компанийн нэр бүрээр, боомт бүрээр гарч байгаа. Төмөр замынх гарч байгаа. Энэ 3 хоорондоо нийцэж байна уу гэдгийг авч үзэх ёстой байгаа юм. Зөрж байвал зөрүүг нь бичих. Тэгэхгүй бол хуудас хуудсанд мэдээлэл байгаа, тэхдээ хоорондоо зөрүүтэй байгаад байгаа. Зөрж болно. Зөрүүнд дүгнэлт хийх ёстой. Тэгэхээр хянан нэгтгэгч мэргэжлийн дүгнэлт хийх ёстой. Ийм газраас авсан мэдээлэл дээр ийм байхаар байна, гэтэл өөр газрын өгсөн мэдээллээс харахад ингэж зөрж байна гэдэг дээр мэргэжлийн дүгнэлт хийгээд тайландаа оруулчихвал ач холбогдолтой болох гээд байдаг. Ноднин бас KPMG-д бас хэлж байсан. Маягтаа өөрчил эсвэл дүгнэлтээ өгөх ёстой.

Н.Оюунцэцэг: Угаасаа зөрнө ш дээ. Манайх чинь мэдээлэл зөвхөн борлуулалтын мэдээгээ өгч байгаа. Манайх дотороо тусдаа экспорт гээд явж байгаа.

Н.Баярсайхан: Тэр экспортын мэдээллийг АМГ-аас бас авах ёстой юм байн..

Н.Оюунцэцэг: Тэгэхээр тэр батлагдсан маягтаа өөрчлөх ёстой юм уу, бид нар чинь Сангийн яамнаас батлагдсан маягтаар л мэдээгээ өгч байгаа.

Н.Баярсайхан: Тэгвэл маягтаа бид нар анхаарах ёстой болж байна. Үүнийг нэгтгэгч зөвлөмж болгоод өгөх нь ач холбогдолтой байх юм

Ж.Батцэнгэл: Бас тооцох аргачлалууд байна л даа. Ямар аргачлалаар тооцож байна.

Н.Баярсайхан: Энэ дээр мэргэжлийн байгууллага дүгнэлтээ өгчих хэрэгтэй. Маягтаа өөрчил эсвэл аргачлалаа өөрчил гээд зөвлөмж өгчих юм бол ярилцаад, сайжруулах шаардлагатай.

Б.Батболд: Зам тээврийн яамнаас мэдээ авч болох юм биш үү. Тээвэрлэлтийн орлого ямар компаниудаас ордог вэ, тэр компаниудын нэр нь гараад ирвэл танай энэ орлогын хэдэн хувийг хааш нь өгдөг вэ гээд. Танайх тээвэр хийж байгаа агаарын, усан тээвэр, төмөр замын тээврүүдээс ямар нэгэн орлого авдаг уу, үгүй юу гэдгийг тодруулчих, ордог бол ямар компаниас орлого ордогийг тодорхой болгочих. Манайд нийт тээвэр хийсний орлого тэдэн төгрөг ордог гэдгийг тодруулах. Тээврээс засгийн газар хэдэн төгрөгийг авдагийг тодорхой болгох.

Ж.Батцэнгэл: Тээврийн мэдээ манайхаас гардаггүй ш дээ. Энэ шинэ зүйл байна.

Н.Эрдэнэцог: Нэмэлт мэдээллийн маягт дээр тээврийн талаар оруулах ёстой. Зам тээврийн яам хураамж авч байж болно. Тэрийг судлая. Концессоор замаа өгсөн бол замын хураамж гэж байгаа.

Д.Эрдэнэчимэг: Хувийн компани тээвэрлэлт хийгээд, орлого олж байгаа, тэрнээсээ төлж байгаа татвар нь орох юм бишүү.

Н.Баярсайхан: Ер нь компаниудын нэмэлт мэдээллийн маягт дээр тээврийн төлбөр гэж нэмэлт оруулбал зүгээр юм байна. Бүртгэгдээгүй орлого чинь энэ болохын биш үү.

Н.Эрдэнэцог: Дараагийнх нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хийсэн эсвэл хүлээн авсан төлбөрийн нэгтгэл, тайлагналын талаар ил тод болгоно.

Ажлын хэсгээс санал гараагүй.

Дараагийнх нь материаллаг байдал болон орон нутагт хийгдэж байгаа шууд төлбөрийн талаар ил тод болгоно.

Н.Баярсайхан: Орон нутагт хийж байгаа шууд төлбөр гэдэг нь Засгийн газарт төвлөрүүлээд шууд хийж байгаа гэсэн үг үү, компаниас шууд төлж байгааг хэлж байна. Уу?

Н.Эрдэнэцог: Компанийн шууд хийгдэж байгааг хэлж байгаа.

Д.Эрдэнэчимэг: Таны хэлж байгаа чинь орон нутгийн шилжүүлэг болчих юм болов уу.

Н.Баярсайхан: Тэгвэл бүтээгдэхүүн хуваах гэрээтэй, газрын тосны компаниуд лицензтэй сумдаа жилийн 5000-с дээш ам.доллар өгч байгаа. Тэр орох юм байна. Тийм үү?

Б.Батболд: Янз бүрийн, ургамал ашигласны, түгээмэл тархацтай ашигт малтмалын газрын татвар төлсөн гэх мэт жижиг татварууд тодорхой болговол зүгээр байна. Орон нутгаас юм ашиглачихаад төлбөрөө дээшээ л өгдөг.

Н.Эрдэнэцог: Орон нутгийн татваруудаа хэлээд байгаа. Шилжүүлэг гээд байгааг АМНАТ-ын 5%, ГНАТ-ийн 30%-ийг аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд шилжүүлнэ. Энд тодорхой бус байгаа зүйл нь компаниуд нийт дүнгээрээ л АМНАТ-ыг тэдийг төлсөн, лицензийн төлбөр тэдийг төлсөн гэхээс биш 30%-ийн хуваарилалт нь Сангийн яам дээр хийгдэж байгаа шүү дээ. Энэ хуваарилалт нь ямар ямар аймаг руу яаж яаж хуваарилагдсан байна гэдгийг хүлээж авсан орлоготой нь тулгах ёстой. Итгэлцүүрийн том журам байдаг юм билээ. Зөвхөн шилжүүлгийг шалгах ёстой. Үүний дагуу Сангийн яам дээр очино гэж бодож байгаа.

Н.Эрдэнэцог: Орлогын задаргааны түвшин ба төрлүүд.

Д.Эрдэнэчимэг: Төслөөр тайлагнах гэж ярьдаг тэ. Нэг компани хэд хэдэн тусай зөвшөөрөлтэй, зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Н.Эрдэнэцог: Энэ бол компаниудын өөрсдийн нягтлан бодох бүртгэлийн бодлогоос хамаарна.

Г.Ганбат: Цахим тайлангаар АМНАТ, Лицензийн төлбөр яг лицензээрээ гарч байгаа. Бусад татварууд гарахгүй. Орон нутгийн төлбөр сумаараа гарч байгаа.

Н.Эрдэнэцог: Орлогоо сегментээр тайлагнах ёстой гэж СТОУС дээр байдаг.

Н.Баярсайхан: ОУИТБС-ын нэгтгэл тайланг аймаг, бүсээр гаргаж болох уу. Дотроо бүлэгтэй. Говийн бүсийн ОУИТБС-ын тайлан гэх мэтээр тайлангаа бэлдэх хэрэгтэй байна. Ингэвэл тайлангийн ашиглалт сайжрах гээд байна. Тайлангаа тодорхой бүлэгтэй болгомоор байна. Ажлын алба болон Германы ОУХАН зэрэг байгууллагууд аймаг, аймгаар нь нэгтгэж дахин хийсэн байна. Тайлангаа дотроо ангилалтай хийвэл зүгээр байна. Хэвлэхдээ 4 бүсээр хэвлээд, хураангуйг нэгтгээд гаргана. Тэгвэл говийн бүсийн хүмүүс зөвхөн говийн бүсийн тайлангаа аваад үзэх нь чухал байна. Болж өгвөл аймаг, аймгаар нь гаргах ёстой. Тэгэхгүй бол нэг зузаан тайлан байхаар аймгаа хайж олох шаардлагатай байна. Тэрийг энэ хэсэгт оруулая.

Нэгтгэл тайлан дээр уул уурхайн үйл ажиллагааг бүсээр нь тайлагнана гэсэн ажлын даалгавар өгөгдсөн байгаа. Хэвлэхдээ 4 бүсээр нь жижиг жижиг хэвлэгдэж гараад, хураангуй тайлан гэж тусдаа нэг гарчихвал ашиглалт нь сайжрах гээд байна. Тэгвэл Говийн бүсийн их хурлын гишүүд тэр бүсийн тайлангаа үзээд явчихна. Болж өгвөл аймгаар нь гаргачихвал зүгээр байна. Тэгэхгүй бол нэг зузаан тайланг чинь Өмнөговийнхон үзэхгүй байна. Хайж хайж аймгийнхаа мэдээллийг олно. Тэрийг энэ хэсэгт оруулмаар байна.

Н.Эрдэнэцог: Цахим тайлангийн системийн найдвартай байдлыг сайжруулах үүднээс системийн ажиллагааг шалгах. Энэ дээр манай IT-н мэргэжилтэн Интерактив, Ажлын хэсгийнхэнтэй уулзаад явж байгаа.

Н.Эрдэнэцог: Мэдээллийн чанарын асуудал: Өмнө жил хийж байсантай адилхан болсон.

Эцэст нь нэмэлт мэдээлэл авах маягтуудаа хийсэн. Энэ маягтууд жилээс жилд сайжраад, манай маягтуудыг KPMG сайжруулаад авч ашигласан байна. Компаниуд энэ маягтын талаар тодорхой ойлголттой болсон учир үүнийг өөрчлөөд байх шаардлагагүй, тогтвортой маягт болчих юм байна гэсэн дүгнэлтэд хүрээд байгаа. Нэмэлт маягтуудыг цахимаар компаниудаас авахаар болсон.

Сая гарсан саналуудыг маягт дээрээ нэмж оруулъя.

Н.Баярсайхан: Ажилчдын мэдээллийг харуулахдаа тухайн орон нутаг буюу аймгаас дотоодын хичнээн ажилтан ажиллаж байгааг маягт дээрээ нэмж оруулах.

Н.Баярсайхан: Компаниудын нийгмийн даатгалын төлөлтийг суманд, аймагт, улсад төлсөн гэж харуулж болох уу? Орон нутагтаа төлбөл сайн байхгүй юу уг нь. Төлж болохгүй гэсэн заалт байхгүй юм байна лээ.

Н.Эрдэнэцог: Нийгмийн даатгал төлөгдөнө, тэр хүн ажилладаггүй, мөнгөө авдаг ийм асуудал байдаг. Орон нутагт төлөгдсөн нийгмийн даатгалын шимтгэл гэж нэмж гаргая. Нийгмийн даатгалын төлөлт цахимжсан.

Н.Баярсайхан: Компани ямар хэмжээгээр тайлангаа задлаж харуулах боломжтой байна, тэрүүгээр нь тодруулах нь зүйтэй байх.

Б.Батболд: Төгсгөлд нь санал хэлэх гээд байна. Өнөөдрийн хурлаас гарсан энэ саналуудаараа тусад нь нэг хүснэгт хийгээд, хэрэгжилтийг нь бид нарт өгөх юм. Өнөөдрийн хуралдаанаас гарсан саналыг тусад нь хүснэгтээр харуулчихвал зүгээр юм уу байна.

Ш.Цолмон: Эхлэлийн тайлангаа хэзээ гаргах вэ?

Н.Эрдэнэцог: Дараа 7 хоногийн 5 дахид драфт тайланг явуулъя.

Маргааш ажлын хэсгийн санал гэдэг дээр бичээд орой явуулна.

Н.Баярсайхан:

1. Торгуулийг суманд, аймагт, улсад гэж харуулах боломж байх уу. Торгуулийн зориулалтыг авах хэрэгтэй байна. Дүгнэлт дээрээ хяналт тавьдаг төрийн байгууллагаар нь торгуулийг ангилж харуулж өгөөч.

2. Цахим тайлангаар өгсөн мэдээллийг анх удаа нэгтгэх гэж байна. Тэгвэл зөвхөн 250 компанийг гэж байхаар бусад жижиг төлбөр төлсөн компаниудын тайланд нэгтгэл хийх зэрэг компани цахимаар тайлан гарч байгаагийн ач холбогдол нь яаж гарч ирж байна. Энэ дээр чанарын ач холбогдол юу байна. Мэргэжлийн байгууллагын хувьд цахим болсны хувьд ач холбогдол нь юу байна гэдэг тал дээр танайх дүгнэлт өгчихмөөр байна. Ер нь хаяад байдаг энэ компаниуд юу болж байдаг байна. Энэ нэгтгэлд шалгуулахгүй байгаа жижиг компаниудыг 2 жилд нэг ч удаа юмуу шалгах ёстой гэж танайх дүгнэлт өгмөөр байна. Дүгнэлт, зөвлөмж гарчихвал хэрэгжих гээд байна.
3. Ер нь тайлан гарлаа. Энэ тайланг төсөв зохиоход, төсвийн хяналт хийхэд, уул уурхайн бодлого тодорхойлоход ингэж ашиглах боломжтой юм байна. БО-ны нөхөн сэргээлт ерөөс хийгдэхгүй байна. Мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийхдээ эцэст нь дүгнэлт оруулна, зөвлөмж гаргана гэж тооцоолоорой.

Н.Эрдэнэцог: Компаниуд торгуулиа төлсөн гэж тайлагнана. Хоорондоо таарахгүй бол зөрүүг нь тодруулна.

Н.Баярсайхан: Зөрүүг тодруулахаас гадна сумын төв торгууль тооцож байна уу, аймаг тооцож байна уу гэдгийг харах гээд байгаа юм. Тэгэхээр торгуулийн зориулалтыг авах хэрэгтэй юм байна. Ямар төрлийн торгууль вэ гэдгийг мэдэх боломж байх уу.

Г.Ганбат: Торгуулийг аймаг, мэргэжлийн хяналт, компани 3 шивж байгаа. Компаниуд сумын түвшинд тайлагнаж байгаа. Цахим тайлан дээр шивчихсэн байгаа. Аймаг шивж байгаа, Мэргэжлийн хяналт шивж байгаа.

Н.Баярсайхан: Тэгвэл үүнийг дүгнэлт дээрээ 2015 онд төдий хэмжээний торгууль ноогджээ. Үүнээс аймгийн түвшинд, МХГ-ын түвшинд гэх мэт хяналт тавьдаг төрийн байгууллагаар нь харуулах дүгнэлтийг тайлангийнхаа төгсгөлд оруулж өгнө үү. Тэгвэл төрийн байгууллагын хариуцлага тооцож байгаа байдал харагдах гээд байна.

Мөн энэ орхигдоод байгаа жижиг компаниудад аудит хийлгэх талаар мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж өгөх хэрэгтэй байна.

Н.Эрдэнэцог: Ноднингийн тайлан дээр ҮАГ манайд төсөв байхгүй гэсэн байна лээ.

Н.Баярсайхан: Танайд дүгнэлт өгчихвөл, ерөнхий сайд ахлаж байгаа учир дараа жилээс үүрэг өгөөд явж болно байх

Д.Батболд хэлсэн үү. айгуул чинь орон нутаг дээр яаж явж байгаа. Жнь: Ноён уул дундуур хайгуул хийхдээ нүхлээд явчихдаг. Нөхөн сэргээлтийн 50% чинь биш байна гэж дүгнэлт гараад ирнэ.

Д.Эрдэнэчимэг: 2015 оны 11 сард Үндэсний чуулган хийгдсэн байгаа. Тэр үндэсний чуулганы дүгнэлтийг өгсөн байгаа. Энэ дээр чухал асуудал яригдсан.

Б.Батболд: БОЯ, СЯ, МХЯ-наас тайлангаа өгөхгүй байгаагаас ажил удааширах уу? Хугацаа хойшлогдох уу?

Н.Эрдэнэцог: Энэ 3 газрын тайланг өгүүлэх асуудлыг Ерөнхий сайдын зөвлөхөөр дамжуулан яаруулъя.

Тайлангийн 2.2, 2.3 дээр санал хэлье.

Түгээмэл тархацтай ордын талаар маш замбараагүй лиценз олгогдсон. Хан-Уул дүүрэг 12, 13-р хороонд ногоо тарьдаг, мод тарьдаг. Лиценз давхцдаг. Энэ дээр нилээд маргаан гардаг. Огт лицензгүй хүмүүс дундуур нь ухдаг. МОУИТБС-ын Хан-Уул дүүргийн зөвлөл УБ хотод 2013 онд байгуулагдсан. Тайлангаа гаргадаггүй, нөхөн сэргээлт хийдэггүй асуудал гараад байна. Туул голын тосгоны төвд нь ухаад хаяцан. Энэ талаар тайланд тусгахгүй бол болохгүй байна. Энд лицензийн маш их будилаан байна. Дураараа ухдаг, координатын дагуу ухдаггүй. Лиценз олголт, бүртгэл, түүнд тавих хяналт гэдэг дээр энэ талаар оруулж өгвөл зүгээр байна.

Г.Ганбат: Одоо маягт гараад, компанийн нэмэлт мэдээлэл дээр Компаниудад тайлангийн мэдээллийг яаж өгөх вэ гэсэн сургалт явуулах ёстой. Тэрийг хэзээ хийх вэ?

Н.Эрдэнэцог: 9 сар гараад хүмүүс амралтын байдлаас эргээд ирэхээр сургалт явуулах төлөвлөгөөтэй байна.

Б.Батболд: Надад нэг санал байна. Та бүхэн энэхүү хурлаас гарсан Ажлын хэсгийн шийдвэрийг тусгасан тэмдэглэл хийгээд, ажлын хэсгийн шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар танилцуулаарай.

Н.Баярсайхан: Тэгэхээр 2 санал байна.

- Гадаад мэргэжилтэнээ илүү оролцуулах ёстой. Тайлан маань үр дүнтэй гарахгүй байх магадлалтай. Техникийн саналаар маш бага санал авсан компани шалгарсан тул санаа зовж байна. Цаашдаа ажлын албанд хэлэхэд тендер зарлахаас өмнө техникийн зөвлөгөө өгдөг, ОУИТБС-ын талаар мэдээлэл өгсөн цуглаан уулзалт хийж байх ёстой юм билээ. Ажлын даалгавраа сайн ойлгоогүй байсан. Аль болох ажлын албатайгаа хамтарч ажиллаасай гэж хүсч байна. Хугацаа бага байгаа, хэцүү нөхцөлд та нар ажиллана.

Ш.Цолмон даргаас асуухад энэ байгууллагын аудит хийгээд байгаа тайланд ажлын албанаас ямар хяналт тавьдаг талаар асуух. Энэ тал дээр анхаарал хандуулаарай. Өнөөдөр Осоргарав гуай ирээгүй байна. Хамгийн их асуудал гаргаж, тендерийг удаашруулсан, зохион байгуулалт, хариуцлагын асуудал харагдаж байна шүү. Өөрсдөө яагаад ирээгүй, зөвхөн та 2 энийг хийчих юмуу? Энийг бас бодохоор байна. Бид нар 10 дахь жилийнхээ тайлангаа гаргах гэж байгаа учраас маш хариуцлагатай ажиллаарай.

- Тайланг болж өгвөл аймгаар, бүсээр гаргаарай. Хэрэгцээнд нийцүүлэх үүднээс мэдээллээ анхнаас нь тэгж тооцоолж цуглуулаарай.

Ш.Цолмон: Ажлын албаны зүгээс бүх бололцоотой дэмжлэгийг үзүүлнэ. Б.Нямаа зөвлөхөөр гарын үсэг зуруулж, шаардуулах юм байвал эрт хэлмээр байна.

3-рт Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн хувьд итгэлтэй байгаа шүү. 10 дахь жилийн тайланг сайн гаргана гэсэн итгэлтэй байгаа. Маргааш өнөөдрийн тэмдэглэлийг ирүүлээд, дараа 7 хоногт эхлэлийн тайланг гаргах юм байна гэж ойлголоо.

Ажлын хэсгийн хурал 13 цаг 10 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,
ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн аудитын менежер

Н.Эрдэнэцог

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ахлах аудитор

Б.Дэлгэрмаа